

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Талархал бол бурханлиг бэлэг

Талархалтай зүрх сэтгэл нь . . . Тэнгэрлэг Эцэгтээ, Түүний бидэнд өгсөн адислалуудад болон эргэн тойрныхоо хүмүүст, бидний амьдралд авчирсан бүх зүйлийнх нь төлөө талархал илэрхийлснээр илэрдэг.

Энэ хэсгийн хуралдаан гайхамшигтай болж байна. Би Сүмийн Ерөнхийлөгчөөр томилогдож байхдаа “Табернеклын найрал дууны зөвлөгч болно” гэсэн нэг л үүргийг би өөртөө хүлээж авсан”. Найрал дуучдаараа би маш их бахархаж байна.

Ээж минь надад нэг удаа “Томми, би чиний хийж буй бүх зүйлээр бахархаж байна. Гэхдээ чамд хэлэх нэг л зүйл байна. Чи төгөлдөр хуураа тоглосоор л байх хэрэгтэй байсан юм” гэж билээ.

Харин би төгөлдөр хуур уруу очиж нэг ая тоглоод: “Ийм л байна даа, төрсөн өдрийн үдэшлэгт явъя” гэв.¹ Тэгээд ээжийнхээ духан дээр нь үнсэхэд тэр намайг тэвэрсэн юм.

Би түүний тухай боддог. Би аавынхаа тухай боддог. Надад гайхалтай нөлөө үзүүлдэг бүх Ерөнхий эрх мэдэлтнүүд болон намайг айлчлах үед зуухандаа тахианы мах чанаж, заримдаа халаасандаа

хэдхэн зоостой байсан бэлэвсэн эгч нарын тухай би боддог.

Би нэгэн үдэш 12 цагийн үед асрамжийн газарт нэгэн хүн дээр зочилсон юм. Намайг ороход хүлээн авагч нь “Тэр унтаж байгаа байхаа, гэхдээ тэр таныг ирвэл заавал сэрээгээрэй, “Тэр ирнэ гэдгийг би мэдэж байна.” гэж хэлсэн гэв.

Би түүний гарыг атгахад намайг нэрээр минь дуудав. Тэр сэрүүн байсан юм. Гарыг минь урууддаа хүргэн “Таныг ирнэ гэдгийг би мэдэж байсан юм” гэж хэлсэн. Би очихгүй байж яаж чадах билээ?

Гайхалтай сонголт хөгжим миний зүрх сэтгэлд тэрхүү замаар хүрч байна.

Хайрт ах, эгч нар аа, бид үнэн, итгэл найдвар, хайрын сүнсээр нөлөөлөгдсөн захиасуудыг сонслоо. Бидний нүглийг цагаатгаж, хэрхэн амьдарч, хэрхэн залбирвал зохицыг бидэнд үзүүлсэн, үйлчлэлээс

ирдэг адислалуудыг үйл хэргээрээ харуулсан, бүр бидний Их Эзэн бөгөөд Аврагч Есүс уруу бидний санаа бодол чиглэлээ.

Бид Түүний тухай Лукийн номын 17-р бүлгээс ийн уншдаг билээ:

“Иерусалим хүрэх замд нь ийм хэрэг болов. Есүс Самари, Галил нутгийн заагаар явж байжээ.

“Түүнийг нэгэн гацаанд хүрч ирэх үед зайдуу зогсож байсан уяман өвчтэй арван хүн Түүнтэй уулзлаа.

“Тэд дуугаа өндөрсгөн, Есүс Эзэнтэн, биднийг өршөөгөөч гэв.

“Есүс тэднийг харангуугаа, ‘Яв’ өөрсдийгөө тахилч нарт үзүүл гэжээ. Тэд явах зуураа цэвэршсэн байлаа.

“Тэдний нэг нь өөрийн эдгэрснийг хараад, буцан ирж, чанга дуугаар Бурханыг алдаршуулан,

“Есүсийн хөлд нь нүүрээрээ унаж, Түүнд талархал өргөв. Тэр Самари хүн байжээ.

“Есүс, арван хүн эдгээсэн биш үү? Харин бусад ес нь хаана байна?

“Бурханд алдрыг нь өргөхөөр энэ харь хүнээс өөр хэн ч буцаж ирсэнгүй юу? гээд.

“Тэр түүнд, Бос өөрийн замаар яв. Итгэл чинь чамайг эдгээлээ гэв.”²

Уяман өвчтэй хүмүүс зугуухан үхэлд хүргэдэг аюулт өвчнөөс бурханлиг хүчээр аврагдаж, амьдралаа шинээр эхлэх боломжтой болжээ. Талархал илэрхийлсэн ганц хүн л Эзэний адислалыг хүртэж, талархал илэрхийлээгүй есөн хүнд Түүний урам хугарсан юм.

Ах эгч нар аа, бид авсан адислалуудынхаа төлөө талархал өргөхөө санадаг бил үү? Чин сэтгэлээсээ талархал илэрхийлэх нь адислалуудаа хүлээн зөвшөөрөхөд төдийгүй,

тэнгэрийн үүдийг нээж, Бурханы хайрыг мэдрэхэд бидэнд тусалдаг.

“Та талархалтайгаар амьдарсан үед бардам зан, амин хувиа хичээгч үзлээс салж, өөрт чинь зуршмал болсон талархлын сүнстэй болж, үүгээрээ амьдралаа адислах болно” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлжээ.³

Библи дэх Матайн номонд талархлын тухай өөр нэг шастир байдаг. Энэ удаад Аврагч талархал өргөжээ. Түүнийг цөлд гурван хоног аялахад 4000 гаруй хүн дагаж явсан байна. Тэд тэднийг өрөвдөн хайрлаж байлаа. Учир нь тэд гурав хоног юу ч идээгүй аж. Гэтэл шавь нар нь “Бид энэ зэлүүд газарт ийм олон хүнийг цатгах талхыг хаанаас олох билээ?” гэжээ. Шавь нар нь бидний олонхийн адил зөвхөн дутагдаж байгаа юмыг л харжээ.

“Есүс, Та нарт хэдэн талх байна? гэв. Тэд, Долоо. Бас хэдэн жижиг загас байна гэлээ.

“[Есүс] хурсан олонд газарт суухыг тушаагаад, долоон талх мөн загасыг авч *талархал өргөн*, хуваагаад, шавь нартаа өгч эхэлсэнд тэд хүмүүст тараан өгөв.”

Аврагч шавь нартаа байсан юманд нь талархал өргөснөөр гайхамшиг тохиосныг харатун. Судраас цааш нь эш татъя: “Бүгд идэж цадаад үлдсэн хэлтэрхийнүүдийг цуглуулахад долон том сагс дүүрсэн байлаа.”⁴

Бид адислалууд дээрээ биш харин дутагдаж байгаа юман дээрээ анхаарал төвлөрүүлдэг үе бидэнд байсан. “Өөртөө байхгүй юманд харамсан гашууддаггүй, харин байгаа юмандаа баярладаг хүн ухаалаг хүн мөн” гэж Грекийн философич Эпиктит хэлжээ.⁵

Талархал бол бурханлиг зарчим мөн. Их Эзэн Бошиглогч Иосефоор дамжуулан өгсөн илчлэлтдээ,

“Чи Их Эзэн Бурхандаа бүх зүйлд талархах ёстой. . . .

“Мөн бүх зүйл дээр Түүний гарыг хүлээн зөвшөөрдөггүй, мөн үүний зарлигуудыг дуулгавартайгаар үл дагадаг тэднээс бусад хүмүүн ямар

ч зүйлээр гэм бурууг үйлддэггүй, эсвээс хэний ч эсрэг түүний уур хилэн дүрэлздэггүй.”⁶

Мормоны Номонд бидэнд хандан “[Бурхан] та нарын дээр бэлэглэдэг тэрхүү олон нигүүлсэл мөн адислалуудын төлөө өдөр бүр талархалтайгаар амьдрах” ёстой хэмээн өгүүлдэг.⁷

Бид өөрсдийн нөхцөл байдлаас үл хамааран, зөвхөн хүлээн авдаг адислалуудаа тунгаан бодоод үзвэл талархах зүйл олон байдаг.

Өнөө үе бол дэлхий дээр амьдрахад гайхамшигтай сайхан үе юм. Өнөөдөр дэлхий дээр буруу зүйл олон байгаа ч, сайн сайхан, зөв зүйл олон бий. Сайн сайхан гэр бүлүүд байна, үр хүүхдээ хайрлаж, тэдний төлөө золиослол хийдэг эцэг эхчүүд, бидний төлөө санаа тавьж тусалдаг найз нөхөд, бидэнд зааж зөвлөдөг багш нар байдаг. Бидний амьдрал янз бүрийн байдалаар адислагдсан юм.

Бид атгаг санаа бодол өвөрлөхгүй, зүрх сэтгэлдээ талархлыг төлөвшүүлсэн үед өөрсдийгөө болон өрөөл бусдыг өргөн дэмжиж чадна. Хэрэв талархалгүй байхыг ноцтой нүгэл гэж үзэх юм бол, талархал илэрхийлэх нь хамгийн эрхэм ариун зүйлд тооцогдоно. Талархал бол хамгийн агуу ариун журам төдийгүй бусад бүх сайн сайхны эх булаг мөн гэж нэг хүн хэлжээ.⁸

Бид зүрх сэтгэлдээ талархлыг хэрхэн төлөвшүүлж болох вэ? Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит энэ асуултанд хариулсан юм. “Талархалтай хүн талархах ёстой зүйлийг дэлхийгээс үй олноор нь олдог. Түүнд сайн зүйлс саараасаа илүү их байдаг. Хайр нь атаа жөтөөг давамгайлж, гэрэл нь түүний амьдралаас харанхуйг хөөн зайлуулдаг. Бардам зан бидний талархлыг үгүй хийж, оронд нь амин хувиа хичээх үзлийг бий болгодог. Талархалтай бөгөөд хайраар дүүрэн нэгний дэргэд байх нь хэчнээн их аз жаргал билээ. Иймээс бид залбиралтайгаар амьдарч Бурхан болоод хүмүүнд талархал өргөдөг зан чанарыг

өөрсдөдөө төлөвшүүлэхэд онцгой анхаарах ёстой” гэж хэлжээ.⁹

Залбиралтайгаар амьдрах нь талархалтай болох тухаар мөн гэдгийг Ерөнхийлөгч Смит энд захисан байна.

Материалаг баялгийг эзэмших нь биднийг аз жаргалтай, талархалтай болгодог уу? Түр зуур аз жаргалтай, талархалтай болгодог байж магадгүй. Гэвч, гүн гүнзгий, удаан үргэлжлэгч аз жаргал, баяр талархлыг бий болгодог зүйлсийг мөнгөөр худалдаж авч болдоггүй. Эдгээрт бидний гэр бүл, сайн мэдээ, дотны найз нөхөд, бидний эрүүл мэнд, авьяас чадвар, эргэн тойрныхоо хүмүүсийн хайр хүндэтгэлийг хүлээх зэрэг багтана. Харамсалтай нь, бид эдгээрийг чухал зүйлд тооцдоггүй болжээ.

“Ихэнх хүмүүс чухал юмсыг байх л ёстой ердийн зүйлс гэж үзэхдээ тун гарамгай” хэмээн Английн зохиолч Олдуос Хаксли бичжээ.¹⁰

Бидний талархлыг хамгийн ихээр хүлээх ёстой хүмүүсийг бид хайхрахгүй өнгөрөх нь олонтаа тохиолддог. Талархлаа илэрхийлэх нь бидний хувьд хэзээ ч бүү хожимдсон байг. Нэг эрэгтэй хайртай хүнээсээ хагацсан тухай: “Аз жаргалтай тэр үеийн тухай би дурсан санаад, хорвоог орхисон түүнийхээ чихэнд амьд байхад нь бараг хэлж байгаагүй талархлын үгсийг хэлж болдог ч болоосой гэж харамсан бодох юм” хэмээн ярьж билээ.¹¹

Хайртай хэн нэгнээсээ хагацах нь бидний зүрх сэтгэлд уй гашуу, харамслыг авчирдаг. Хайр талархлаа аль болох олон удаа илэрхийлж уй гашуу, харамслыг багасгагч. Талархал илэрхийлэх нь хэзээ хожимдсон байхыг бид хэзээ ч мэдэхгүй шүү дээ.

Тэнгэрлэг Эцэгтэй түүний олон адислалын төлөө, эргэн тойрныхоо хүмүүст бидний амьдралд тэдний авчирсан бүх зүйлийн төлөө талархал илэрхийлснээр бид талархагч зүрх сэтгэлтэй болно. Энэ нь ухамсартай хүч чармайлт, наад тал нь л талархалд суралцаж, үүнийг өөрсдөдөө төлөвшүүлэхийг биднээс

шаардана. Бид байнга талархалтай байж, талархлаа илэрхийлэхийг боддог ч мартчихдаг эсвэл цаг олддоггүй, нэг мэдэхэд өнгөрчихсөн байдаг. Талархах ёстойгоо мэдэрсэн ч талархал илэрхийлэхгүй байх нь бэлэг бэлдэж боочихоод түүнийгээ өгөөгүйтэй адилхан юм гэж нэг хүн хэлсэн байдаг.¹²

Бид амьдралдаа сорилт бэрхшээлтэй тулгарсан үед адислалууд дээрээ анхаарал төвлөрүүлэхэд ихэнхдээ хэцүү байдаг. Гэвч, хэрэв бид сайн эрж хайж, нарийн харах юм бол, бидэнд ямар их зүйл өгөгдсөнийг ухаарч мэдрэх болно.

Сорилт бэрхшээлтэй тулгарсан үедээ адислалуудаа олж харсан нэг гэр бүлийн тухай өгүүлийг би та нартай хуваалцъя. Би энэ өгүүлийг олон жилийн өмнө уншсан бөгөөд оюун ухаандаа хадгалж явдгийн учир нь доторх захиаст нь байгаа юм. Өгүүлийг Гордон Грин бичсэн бөгөөд 50 гаруй жилийн тэртээ Америкийн нэг сэтгүүлд нийтлэгдсэн юм.

Гордон Канадын нэг ферм дээр хэрхэн өссөн тухайгаа өгүүлжээ. Хичээлийн дараа бусад хүүхдүүд бөмбөг тоглохоор юм уу усанд сэлэхээр явдаг байсан бол Гордон болон дүү нар нь гэр уруугаа яардаг байлаа. Аав нь тэдний ажил ямар үнэ цэнэтэйг ойлгуулахдаа чадварлаг нэгэн байсан гэдэг. Ургац хураалтын дараа гэр бүлээрээ тэмдэглэдэг Талархлын өдөр аав нь өөрсдөдөө байгаа бүх хүнс хоолоо тоолдог байсан нь түүнийхээ төлөө талархал илэрхийлэх зорилготой байжээ.

Талархлын өглөө тэр хүүхдүүдээ зооринд дагуулан орж алимтай торхнууд, хувинтай чихрийн манжин, элсэнд булсан лууван, шуудайтай төмснүүд, тавиур дүүрэн вандуй, эрдэнэ шиш, шош, жимсний цэлцэгнүүр, гүзээлзгэнэ, бусад дармал жимс, ногоонуудыг үзүүлдэг байлаа. Тэр юм бүхнийг хүүхдүүдээр анхааралтай тоолуулдаг байжээ. Дараа нь тэд амбаар уруу очиж, тэнд хэчнээн тонн өвс, үр тарианы агуулахад хэчнээн торх тариа байгааг тоолдог байв. Тэд

үхэр, гахай, тахиа, цацагт хяруул, галуунуудыг тоолно. Аав нь хүүхдүүддээ хэчнээн хэмжээний хүнс, бусад хэрэгцээт зүйлс байгааг мэдэхийг хүсдэг гэж хэлдэг байсан ч, үнэндээ бол Бурхан тэднийг ажлынх нь төлөө хэчнээн ихээр адисалж, шагнасныг талархлын тэр өдөр хүүхдүүд нь ойлгоосой гэж хүсдэгийг тэд мэддэг байлаа. Эцэст нь тэд ээжийнхээ бэлтгэсэн баярын ширээнд суух үед ямар нэг адислалыг мэдэрдэг байв.

Харин тэдэнд талархах юм бараг байгаагүй тэр нэгэн жил Талархлын өдрөөр хамгийн их талархалтай байсан тухай санадгаа Гордон өгүүлжээ.

Тэр жил уг нь дажгүй эхэлсэн аж: Тэдэнд нэлээд өвс, их хэмжээний үр, дөрвөн торой байснаас гадна аавд нь ихэнх фермчдийн мөрөөдөл болсон ачиж буулгагч өвсний машин худалдаж авахын тулд хадгалсан багахан мөнгө байжээ. Тэр жил бас тэдний хот цахилгаан эрчим хүчтэй болсон ч, тэдний бэл бэнчин хүрээгүй учир гэрэл тогтой болж чадаагүй гэнэ.

Нэг шөнө Гордонгийн ээж уул овоо шиг их хувцас хунар угааж байтал аав нь орж ирээд, нидрүүлийг авч эхнэрээ жаахан амарч байгаад нэхэх, сүлжих ажлаа хийхийг хүсэв. “Чи юм угаахад унтахаасаа илүү цаг зарцуулах юм. Бид энэ хүнд хүчир ажлаа хөнгөвчилж, цахилгаан эрчим хүчийг ашиглавал яасан юм?” гэж тэр хэлжээ. Эхнэр нь сайхан үг дуулаад баярласан ч нөгөөх худалдан авч чадаагүй өвс ачиж буулгагч машины тухай бодоод нулимс дуслуулсан гэнэ.

Тэгээд тэр жил тэднийх цахилгаан эрчим хүчтэй болсон гэнэ. Хэдийгээр их гоё биш ч гэсэн угаалгын машин худалдаж авсан нь өдөржингөө өөрөө ажиллана, мөн таазнаас унжих гэрлийн шил хурц гэрэл цацруулан нүд булаана. Гол хайчилж хийгээд, тосоор дүүргэж асаадаг дэнлүү, юм угаах гэж утаа тортог савсуулсан пийшин галлах шаардлагагүй болсон аж. Дэнлүүнүүдийг дээврийн хонгилд гаргаж тавьжээ.

Тэдний ферм цахилгаан эрчим хүчтэй болсон нь тэр жил тэдэнд тохиосон сүүлчийн боломж байлаа. Тариа дөнгөж соёолж эхэлтэл бороо орж эхлэх нь тэр. Эцэстээ ус татрахад соёолж байсан тариа урсан байв. Тэд дахин тариалсан ч бүр их бороо орж, соёолж байсан тариа газарт налж, төмс нь шаварт шигдэн ялзарсан гэнэ. Тэд өсгөн үржүүлэх гэж байсан хоёр үнээ, бүх гахай, бусад малаа маш хямдхан заржээ. Учир нь хүн бүр л ингэж малаа зарахаас аргагүйд хүрсэн байлаа. Тэр жил тэдний хураасан бүх ургац гэвэл бороон шуургыг яаж ийгээд тэсч гарсан багахан манжин л байлаа.

Тэгтэл Талархлын өдөр хүрээд ирэх нь тэр. “Энэ жил энэ өдрийг мартвал дээр биш үү. Бидэнд яахдаа ганц галуу ч үлдсэнгүй шүү дээ” гэж ээж нь хэлжээ.

Гэвч Талархлын өдрийн өглөө Гордонгийн аав нэг молтогчин туулай авчраад, туулайн махаар хоол хийхийг эхнэрээсээ хүсэв. Туулайн мах хатуу, хоол хийхэд их хугацаа шаардагдах учраас тэр ажлаа дурамжхан эхэлжээ. Туулайн махыг манжинтай хамт ширээн дээр тавьсан ч хүүхдүүд нь идсэнгүй. Гордонгийн ээж уйлахад аав нь дээврийн хонгил өөд гарч, дэнлүүт авчран ширээн тавьж асаагаад, цахилгаан чийдэнг унтраа гэж хүүхдүүддээ хэлжээ. Зөвхөн дэнлүү үлдсэн үед тэд өмнө нь хэчнээн харанхуй байсанд итгэж ядан байлаа. Тэд цахилгаан гэрэлгүйгээр өмнө нь юм бүхнийг яаж харж байсандаа гайхжээ.

Хоолоо адисалсны дараа бүгд нөгөө туулайны махаа идлээ. Хоолож дуусаад бүгдээрээ чимээгүй сууцгааж байв. Гордон

“Тосон дэнгийн даруухан бүдэг гэрэлд бид юм бүхнийг дахин тод харж байлаа. . . .

Хоол сайхан болсон байлаа. Молтогчин туулайн мах цацагт хяруулын мах шиг сайхан амттай, манжин хэчнээн зөөлхөн байсан гээч. . . .

Манайх гэдэг айл юм юмаар дутагдаж байсан ч, бидэнд

бол баян л байлаа” гэж бичсэн байлаа.¹³

Ах эгч нар аа, талархал илэрхийлэх нь ач буянтай, хүндлэлтэй, эрхэм сайхан үйлс мөн. Зүрх сэтгэлдээ ямагт талархалтайгаар амьдрах нь тэнгэрт хүрэх зам юм.

Бид талархал илэрхийлэх ёстой бүх зүйл дээрээ нэмж, Их Эзэн бөгөөд Аврагч, Есүс Христэд талархлаа үргэлж илэрхийлж байхын төлөө би залбирч байна. Түүний алдар суут сайн мэдээ: Бид хаанаас ирсэн бэ? Бид яагаад энд байгаа юм бэ? Биднийг үхэхэд бидний сүнс хаана очих вэ? гэсэн амьдралын хамгийн чухал асуултуудад хариу өгдөг билээ. Сайн мэдээ харанхуйд амьдардаг хүмүүст бурханлиг үнэний гэрлийг авчирдаг.

Тэрээр бидэнд хэрхэн залбиралыг заасан юм. Тэр бидэнд хэрхэн амьдрахыг бас хэрхэн үхэхийг заасан юм. Түүний амьдрал бол хайрын өв юм. Өвчтэйг Тэр эдгээж, ядуучууд, хавчигдан дарлагдсдыг Тэр өргөж, нүгэлтнүүдийг уучилж байлаа.

Тэр цор ганцаар байлаа. Зарим Төлөөлөгчид нь эргэлзэж, нэг нь

Түүнээс урвасан билээ. Ромын цэргүүд Түүний хавиргыг цоо хатгасан юм. Уурлан хилэгнэсэн цугларагсад Түүний амийг хөнөөсөн юм. Гэсэн ч Голготын гүвээнээс, “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” гэсэн Түүний өрөвч сэтгэлийн үгс цуурайтсан билээ.¹⁴

Үзэн ядагдсан, уй гашуутай энэ хүн хэн байв аа?¹⁵ Сүр жавхлангийн энэ хаан,¹⁶ Эздийн Их Эзэн хэн бэ? Тэр бол бидний Эзэн. Тэр бол бидний Аврагч. Тэр бол Бурханы Хүү. Тэр бол бидний авралын зохиогч. Тэр, Намайг дага хэмээн уриалан дуудаж байна.”¹⁷ Тэрээр, “Явж үүний адил үйлдэгтүн” хэмээн зааварлаж байна.¹⁸ Тэрээр, “Миний тушаалуудыг сахь” хэмээн зарлиглаж байна.¹⁹

Түүнийг дагацгаая. Түүний үлгэр жишээг дуурайцгаая. Түүний үгсийг дуулгавартай дагацгаая. Ингэснээр бид талархлын бурханлиг бэлгийг Түүнд өргөн барих болно.

Бид хувийн амьдралдаа талархлын гайхамшигт хүчийг үргэлж мэдэрч байхын төлөө би зүрх

сэтгэлийнхээ чин үнэн залбирлыг өргөж байна. Талархлын энэхүү гайхамшигт хүч бидний зүрх сэтгэлд үүрд шингэх болтугай. Есүс Христийн ариун нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Жон Томпсон, “Төрсөн өдрийн үдэшлэг” *Teaching Little Fingers to Play* (1936), 8.
2. Лук 17:11-19
3. *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 638.
4. Матай 15:32-38-ийг үз.
5. *The Discourses of Epictetus; with the Encheiridion and Fragments*, trans. George Long (1888), 429.
6. С ба Г 59:7, 21
7. Аама 34:38.
8. Cicero, in *A New Dictionary of Quotations on Historical Principles*, sel. H. L. Mencken (1942), 491.
9. Смит, Жозеф Ф., *Gospel Doctrine*, 5th Edition [1939], х. 263.
10. Aldous Huxley, *Themes and Variations* (1954), 66.
11. William H. Davies, *The Autobiography of a Super-Tramp* (1908), 4.
12. William Arthur Ward, in Allen Klein, comp., *Change Your Life!* (2010), 15.
13. Green, Gordon, *Reader's Digest*, 1956 оны 11-р сар.
14. Лук 23:34
15. Исаиа 53:3
16. Дуулал 24:8
17. Матай 4:19
18. Лук 10:37
19. Иохан 14:15.

Бидний үед зориулсан сургаал

“Бидний үед зориулсан сургаал”-ыг Санваартны анги болон Нийгмийн Халамжийн бүлэгт сарын дөрөв дэх бүтэн сайн өдөр заана. Хичээл бүрийг хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр хэлсэн нэг юм уу түүнээс олон үгээр бэлтгэнэ. Гадас болон дүүргийн ерөнхийлөгч нар ашиглах сэдвээ сонгож болно, эсвэл тэд бишоп болон салбарын ерөнхийлөгч нарт сонгохыг даалгаж болно. Удирдагч нар Мелкизедек Санваартан ах нар болон Нийгмийн Халамжийн бүлгийн эгч нар нэг бүтэн сайн өдөр, ижил хичээл үзэхэд анхаарах хэрэгтэй.

Дөрөв дэх бүтэн сайн өдөр ирж буй хүмүүс сүүлд гарсан чуулганы сэтгүүлийг авчирч судлахыг урамшуулж байна.

Хэлсэн үгнээс хичээлд бэлтгэх зөвлөмж

Хичээлийг судалж, заахад Ариун Сүнс тантай хамт байж болохын тулд залбир. Та өөр

материал ашиглан хичээлээ бэлдэхийг хүсч магадгүй, гэвч чуулган дээр хэлсэн үг нь батлагдсан хөтөлбөр юм. Таны үүрэг бол Сүмийн хамгийн сүүлийн ерөнхий чуулган дээр заагдсан сайн мэдээг сурч, түүний дагуу амьдрахад нь бусдад туслах юм.


Материалаа давтан уншиж, ангийн гишүүдийн хэрэгцээнд тохирох зарчмууд болон сургаалыг эрж хай. Түүнчлэн эдгээр үнэнийг заахад тань туслах түүхүүд, судрын эшлэлүүд болон өгүүлэмжийг уг сэдвээсээ хай.

Зарчмууд болон сургаалыг яаж заахаа тоймло. Гаргасан тоймдоо ангийн гишүүдэд туслах асуултуудыг оруул:

- Яриан дахь зарчим болон сургаалыг ол.
- Тэдгээрийн утгыг тунгаан бод.
- Ойлголт, санаа бодол, туршлага болон гэрчлэлээ хуваалц.
- Эдгээр зарчмууд болон сургаалыг тэдний амьдралтай холбо.

СARУУД	ДӨРӨВ ДЭХ БҮТЭН САЙНЫ ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛУУД
2010 оны 11-р сараас 2011 оны 4-р сар хүртэл	Хэлсэн үг 2010 оны 11-р сарын <i>Лиакхона</i> сэтгүүл дээр гарах болно*
2011 оны 5-р сар—2011 оны 10-р сар	Хэлсэн үг 2011 оны 5-р сарын <i>Лиакхона</i> сэтгүүл дээр гарах болно*

*Эдгээр хэлсэн үгийг conference.lds.org хаягаар (олон хэл дээр) унших боломжтой.



Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх

Хамгийн чухал зүйлсийн тухай

Хэрвээ амьдрал, амьдралын хурдац болон олон дарамтууд амьдралын баяр баяслыг мэдрэхэд тань саад болж байгаа бол энэ нь юунаас хамааралтай вэ гэдэгт анхаарлаа хандуулах цаг биш юм.

Байгалийг судалснаар амьдралын тухай хэчнээн ихийг мэдэж авч болох нь үнэхээр гайхамшигтай зүйл юм. Жишээлбэл, эрдэмтэд модны цагираг хараад л хэчнээн зуун, бүр хэчнээн мянган жилийн өмнө цаг уур болон ургах нөхцөл байдал ямар байсан талаар мэдлэг дээрээ тулгуурлан оношилдог. Модны ургалтыг судалснаар бидний сурч болох нэгэн зүйл бол нөхцөл байдал зохимжтой үед моднууд нь энгийн хурдтай ургадаг. Харин хатуу ширүүн улиралд ургалт нь удааширч, эсэн мэнд байхад нь зайлшгүй гол зүйлст хүчээ зориулдаг юм.

Одоо та нар, “За тэр бүгд сайхан л зүйлс байна. Гэхдээ энэ нь онгоц нисгэхтэй ямар хамаатай юм бэ?” гэж бодож байж магадгүй. За би та нарт энэ тухай хэлье.

Та нарын нислэгийн үеэр онгоц донслох тохиолдол болж байсан уу? Донслохын хамгийн нийтлэг

шалтгаан нь гэнэтийн агаарын хөдлөлтийн өөрчлөлтөөс болоод онгоцны хошуу дээш доош нэг хажуугаас нөгөө тал уруу шидэгдэж, мөн онгоц хөрвөхөд хүрдэг. Онгоцнууд нь бидний жирийн нислэгийн үеэр тохиолдох ямар ч зүйлээс хамаагүй илүү хүчтэй донслохыг даван гарахаар хийгдсэн байдаг ч зорчигчид сандарч тэвдэж болно.

Онгоц донсолж эхлэхэд нисгэгчид юу хийдэг гэж та нар бодож байна? Оюутан нисгэгч нь хурдхан шиг өнгөрөөхийн тулд хурдаа нэмэх нь зөв арга гэж бодож магадгүй. Гэвч энэ нь харин буруу зүйл байж болох юм. Мэргэжлийн нисгэгч донсолж байхад явах тохиромжтой хурд гэж байдаг ба энэ нь онгоц донслохын сөрөг нөлөөг багасгадаг гэдгийг ойлгодог. Ихэнхдээ энэ нь хурдаа багасгах гэсэн утгатай байдаг. Энэхүү зарчим нь замын хурд сааруулах газрын овгор гадаргууд

мөн адил хамааралтай юм.

Иймээс сөрөг нөхцөл байдалтай тулгарсан үедээ бага зэрэг удааширч, явдлаа тогтворжуулж, зайлшгүй чухал зүйл дээр анхаарах нь маш сайн зөвлөгөө юм.

Орчин үеийн амьдралын хурдац

Энэ нь энгийн боловч маш чухал сургамж юм. Мод болон шуурганы хувьд бол энэ нь учир зүйтэй зүйл гэж санагдаж болох ч эдгээр зарчмуудыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлэх үедээ энэхүү сургамжийг огтхон ч тоодоггүй нь гайхалтай юм. Дарамт ихсэж, гай зовлон, гамшиг тохиолдсон үед бид хурдацаа нэмэх хэрэгтэй гэж үзэн урьдын улайрсан хурдацтайгаараа юмуу эсвэл бүр илүү хурдасгах нь элбэг тохиолддог.

Онгоц донслох, саад бэрхшээлээс хамааралгүй үргэлж өсөн нэмэгддэг хурдаар урагшилдаг нь орчин үеийн амьдралын шинж тэмдгүүдийн нэг юм.

Шударгаар хэлэхэд завгүй байх нь амар байдаг. Бид цагийн хуваариасаа хэтэрсэн хийх зүйлсийн жагсаалтыг гаргаж чадна. Тэр байтугай хийх ёстой зүйлсийнх нь жагсаалт нь хэр урт байгаагаас өөрсдийнх нь хувийн үнэ цэнэ шалтгаалдаг гэж зарим хүмүүс бодож ч болох юм. Тэдгээр хүмүүс ядарч, дарамтад орсон үедээ ч хурал цуглаан болон бусад чухал биш жижиг зүйлсээр бүх чөлөөт цагаа дүүргэдэг. Тэд шаардлагагүй зүйлсээр амьдралаа төвөгтэй болгодог учраас тэд ихэнх тохиолдолд уур уцаар нь ихсэж, баяр хөөр нь багасаж, амьдралын сайн

сайхныг мэдэрдэггүй юм.

Хэтрүүлэх юм бол ямар ч ариун журам нь бузар үйл болж болдог билээ. Цагаа хэтрүүлэн төлөвлөх нь үүнд орно. Ингэснээр ололт амжилт нь дарамт болж, хүсэл эрмэлзэл нь хүзүүндээ зүүсэн тээрмийн хүнд чулуу мэт санагдах үе ирдэг.

Хариулт шийдвэр нь юу вэ?

Мэргэн хүн модны цагираг, агаарын донслохын сургамжийг ойлгож, амьдралдаа хэрэглэдэг. Тэд өдөр бүрийн амьдралын улайрч яарсан байдалд уруу татагдахаас татгалздаг. Тэд “амьдралд хурдыг нь ихэсгэхээс илүү их зүйл байдаг” гэсэн зөвлөгөөг дагадаг.¹ Товчоор хэлбэл тэд хамгийн чухал зүйлс дээр анхаардаг билээ.

Ахлагч Даллин Х.Өүкс саяхны ерөнхий чуулган дээр ингэж заажээ: “Бидний Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлж, бидний гэр бүлүүдийг хүчирхэгжүүлдэг тэр илүү сайн юмуу хамгийн сайн зүйлсийг сонгохын тулд зарим нэг сайн зүйлсийг ардаа орхих ёстой.”²

Тэрхүү хамгийн сайн зүйлсийг хайх нь биднийг Есүс Христийн сайн мэдээний үндсэн зарчмууд уруу заавал хөтөлдөг. Үүнд хайртай, мөнхийн бөгөөд бүхнийг мэдэгч Тэнгэр дэх Эцэгийн маань бидэнд илчилсэн энгийн бөгөөд гайхамшигт үнэнүүд ордог билээ. Эдгээр үндсэн сургаал, зарчмууд нь хүүхэд хүртэл ойлгохоор энгийн байдаг боловч амьдралын хамгийн төвөгтэй асуултуудад хариултыг өгдөг юм.

Заримдаа бид нарийн төвөгтэй шийдвэрийг хүссэнээс болоод эгэл жирийн байдлаас ирдэг тодорхой бөгөөд сайн сайхан байдлыг сайшаадаггүй билээ.

Жишээлбэл: сансрын нисгэгчид сансарт тосон бал гардаггүй гэдгийг мэдэж авсан юм. Тэгээд хэдэн маш ухаантай хүмүүс энэхүү асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж эхэлжээ. Мянга мянган цаг, сая сая доллар зарцуулсны дараа

эцэст нь тэд хаана ч, ямар ч хэмд бараг ямар ч гадаргуу дээр бичиж болох балыг зохион бүтээжээ. Гэвч энэ асуудал шийдэгдтэл сансрын нисгэгчид юу хэрэглэсэн бэ? Тэд зүгээр л харандаа хэрэглэсэн юм.

Леонардо Да Винчи, “Эгэл жирийн зүйлс нь хамгийн агуу нарийн зүйлс юм” гэж хэлжээ.³ Аз жаргалын Төлөвлөгөө болон Авралын Төлөвлөгөөний үндсэн зарчмуудыг хараад бид Тэнгэрлэг Эцэгийн мэргэн ухааны сайн сайхныг энгийн бөгөөд тодорхой байдлаар нь олж харан, үүнд талархдаг билээ. Иймээс өөрсдийн арга замыг Түүний арга замаар солих нь бидний мэргэн ухааны эхлэл болдог.

ХЭМД

Америкийн хөл бөмбөгийн нэгэн нэртэй дасгалжуулагч, Винс Ломбарди сургалт бүрийнхээ хамгийн анхны өдөр нь байнга нэгэн зүйлийг давтдаг байсан тухай түүх байдаг. Тэрээр хөл бөмбөгийг гартаа барин, энэ спортыг олон жил тоглож буй тамирчдад хандан, “Залуучуудаа, . . . энэ бол хөл бөмбөг” гэж хэлдэг байв. Тэрээр хөл бөмбөгийн хэмжээ, хэлбэр, хэрхэн өшиглөж болох болон хэрхэн авч дамжуулах талаар хэлдэг байжээ. Тэгээд тэрээр багийг хоосон талбайд аваачин, “Энэ бол хөл бөмбөгийн талбай” гэж хэлдэг байв. Тэрээр тэднийг тойруулан алхуулж, хэмжээ, хэлбэр, дүрэм болон энэ спортыг хэрхэн тоглодгийг тайлбарладаг байжээ.⁴

Туршлагатай тамирчид ч, баг ч үндсэн гол зүйлсийг эзэмшиж байж л агуу сайн болдог гэдгийг энэ дасгалжуулагч мэддэг байжээ. Тэд нарийн төвөгтэй чадварыг сурахад цагаа зарцуулсан ч энэхүү спортын үндсэн гол зүйлсийг эзэмшлээ аварга баг болж чадахгүй юм.

Бидний ихэнх нь үндсэн гол зүйлс хэчнээн чухал болохыг зөн совингоороо мэддэг гэж би бодож байна. Гэвч заримдаа бид илүү дур булаамаар мэт санагдах зүйлст

сэтгэл татагддаг билээ.

Хэвлэгдсэн материал, олон нийтийн өргөн хүрээтэй мэдээлэл болон электрон багаж, зэмсгүүд нь бүгд зөвөөр хэрэглэх юм бол бидэнд тус болдог. Гэвч мөн буруу зугаа цэнгэл юмуу бусдаас хөндийрүүлэх аюултай зүйл болж болно.

Гэвч эдгээр өчнөөн олон дуу хоолой болон сонголтууд дунд Галилийн даруу Эр гар сунган зогсож л байна. Хүлээж л байна. Түүний захиас нь энгийн: “Ирж, намайг дага.”⁵ Тэрээр хүчтэй микрофоноор ярьдаггүй харин намуун хүнгэнэх дуугаар ярьдаг.⁶ Биднийг тал бүрээс дайрах янз бүрийн мэдээлүүдийн урсгал дунд сайн мэдээний үндсэн захиас гээгдэх нь хялбар байдаг.

Ариун судрууд болон амьд бошиглогч нарын хэлсэн үгс нь сайн мэдээний үндсэн сургаалууд болон зарчмуудыг онцолсон байдаг. Эдгээр үндсэн зарчмууд болон цэвэр ариун сургаалд бид яагаад эргээд ханддаг вэ гэвэл, эдгээр нь гүн утга учрын үнэний үүд юм. Эдгээр нь бидэнд өөрөөр хэлбэл ухаарах чадвараас минь хэтэрсэн агуу чухал туршлагуудыг үзэх эхлэл болдог. Эдгээр энгийн, үндсэн зарчмууд нь Бурхан болон хүмүүн нь эвтэй амьдрахын түлхүүр юм. Эдгээр нь тэнгэрийн цонхыг нээх түлхүүрүүд юм. Эдгээр нь Өөрийг нь сонсож дагадаг Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ амласан тэр амар амгалан, баяр баясгалан уруу биднийг хөтөлдөг.

Ах Эгч нараа, бид бага зэрэг удааширч, нөхцөл байдалдаа тохирсон хурдаар урагшилж, зайлшгүй зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлэн дээшээ харснаар хамгийн чухал зүйлсийг үнэн байдлаар нь харах нь бидэнд чухал юм. Мөнхийн аз жаргалын амлалт бүхий, дүүрэн ба үр шимтэй мөнх бус амьдралын суурь болох, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ өгсөн тэрхүү үндсэн заавруудыг санаж явцгаая. “Мөн эдгээр бүх зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд

хийгддэг байхыг мэдэгтүн, учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй, тэгснээр тэр шагналыг хожиж болохын тулд бөлгөө.”⁷

Ах Эгч нараа, хамгийн чухал зүйлсийг хичээнгүйлэн хийх нь биднийг дэлхийн Аврагч уруу хөтлөх болно. Тэгээд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглодог.⁸ Нарийн төвөгтэй, эргэлзээтэй, яаруу орчин үеийн амьдралд нь энэ нь уг “илүү дөт зам” юм.⁹

Тэгвэл гол үндсэн зүйлс гэж юу вэ?

Бид Тэнгэрлэг Эцэгтээ хандан хамгийн чухал зүйлсийн талаар Түүний мэргэн ухааныг асуун хандахдаа, бид дараах гол дөрвөн харилцааны тухай дахин дахин сурдаг. Үүнд Бурхан бидний хоорондох харилцаа, гэр бүлийн харилцаа, найз нөхдийн харилцаа, мөн бидний өөрсөдтэйгөө харилцах харилцаа. Бид өөрсдийн амьдралыг оюун санаагаараа шинжиж үзвэл хэрхэн уг илүү давуу замаас холдсноо харах болно. Бидний ойлголтын элмий нээгдснээр, бид өөрсдийн зүрх сэтгэлээ ариусгаж, амьдралаа дахин шинээр чиглүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй байгааг олж харах юм.

Нэгдүгээрт, Бурхан бидний хоорондох харилцаа бол хамгийн нандин бөгөөд зайлшгүй юм. Бид Түүний сүнсэн хүүхдүүд юм. Тэр бидний Эцэг. Тэр бидэнд аз жаргалыг хүсдэг. Бид Түүнийг хайх хэрээр, Түүний Хүү Есүс Христийн талаар сурах хэрээр, Ариун Сүнсний нөлөөнд зүрх сэтгэлээ нээх хэрээр л бидний амьдрал илүү тогтвортой бөгөөд амар амгалан болдог билээ. Бид Бурханы мөнхийн төлөвлөгөөний дагуу амьдарч, Түүний зарлигуудыг дагахын тулд чадах бүхнээ хийх аваас

бид илүү агуу амар амгалан, баяр баясгалан болон амжилтыг мэдрэх болно.

Бид Тэнгэрлэг Эцэгийн тухай сурч, Түүнтэй ярьж, нүглээ наманчилж, Есүс Христийг идэвхтэйгээр дагаснаар Түүнтэй харилцаагаа хөгжүүлдэг. “Хэн ч [Христээр] дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.”¹⁰ Бурхантай харьцах харьцаагаа сайжруулахын тулд бид ганцаараа байхдаа Түүнтэй цагийг өнгөрүүлэх хэрэгтэй. Бурхантай харилцаагаа хүчирхэгжүүлэхийн тулд бид Түүнтэй ганцаарантай нь утга бүхий цаг зарцуулах хэрэгтэй. Өдөр бүрийн хувийн залбирал болон судраас суралцахдаа анхаарч, үргэлж ариун сүмийн эрхийн бичгээ хүчинтэй байлгахыг хичээхэд анхаарах хэрэгтэй. “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” гэсэн дуулын урилгад анхаарлаа хандуулцгаая.¹¹

Хоёрдугаар харилцаа нь бидний өөрсдийн гэр бүлтэйгээ харьцах харилцаа юм.¹² Өөр ямар ч амжилтаар орлуулж болшгүй чухал учраас гэр бүлийн харилцаагаа чухалчлан үзэх хэрэгтэй. Бид гэр бүлээрээ оройн хоол идэх, гэр бүлийн үдэш хийх, болон зүгээр хамтдаа хөгжилтэй байх зэрэг энгийн зүйлсийг хамтдаа хийснээр ойр дотно, үнэнч харилцааг бий болгодог. Гэр бүлийн харилцаанд *хайр* гэдэг үгийг *ц-а-г*, цаг гэж үсэглэдэг юм. Бие биедээ цаг зарцуулах нь эвтэй найртай гэр бүлийн түлхүүр юм. Бид нэг нэгнийхээ тухай биш харин нэг нэгэнтэйгээ ярьдаг. Бид бие биеэсээ сурч, адил зан чанар болон ялгаандаа талархдаг. Бид гэр бүлийн залбирал, сайн мэдээг суралцах болон Ням гарагт шүтэн биширснээр Бурхан уруу хамтдаа очих бурханлиг холбоог үүсгэдэг.

Гуравдугаар гол харилцаа нь бидний нөхөдтэйгөө харилцах харилцаа юм. Бид энэ харилцааг бусдын хэрэгцээнд эмзэгээр хандаж, тэдэнд үйлчилж, өөрсдийн цаг болон авьяасаа зориулан хүн нэг бүртэй харилцааг бий

болгодог билээ. Өндөр нас болон өвчинд шаналсан нэгэн эгч нэг их зүйлийг хийж чадахгүй ч бусдыг сонсож чадна гэж шийдсэнд нь би гайхширсан билээ. Иймээс долоо хоног бүр тэрээр санаа сэтгэл нь зовсон, урам хугарсан хүмүүсийг хайж, тэднийг сонсон тэдэнтэй цагаа өнгөрүүлдэг байжээ. Маш олон хүний амьдралд тэрээр ямар агуу адислал болов.

Дөрөвдүгээр гол харилцаа нь бидний өөрсөдтэйгөө харилцах харилцаа. Бид өөрсөдтэйгөө харилцах харилцаа байдаг гэж бодоход хачин санагдаж болох юм. Гэвч энэ нь үнэхээр байдаг юм. Зарим хүмүүс өөртэйгөө таардаггүй. Тэд бүр өөрсдийгөө үзэн ядаж бүх л өдөржингөө өөрсдийгөө шүүмжилж, өөртөө сэтгэл дундуур байдаг. Та бүхэн яаруу байдлаа багасгаж, өөрсдийгөө илүү сайн мэдэж авахад цаг зориулахыг би санал болгож байна. Байгалын дунд алхаж бай, нар мандахыг харж бай, Бурханы бүтээлүүдэд баясч бай, сэргээгдсэн сайн мэдээний үнэнүүдийг тунгаан бодоод мөн эдгээр нь чиний хувьд ямар утга учиртайг олж мэдэж бай. Бурхан чамайг Өөрийн бурханлаг чадавхтай хайрт охин хайрт хүүгээ гэж хардаг шиг өөрийгөө харж сур.

Ариун нандин Сайн мэдээнд баяс

Ах эгч нараа, мэргэн байцгаая. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сургаалт цэвэр усанд хандацгаая. Үүнээс энгийн бөгөөд тодорхой байдлаар нь баяртайгаар хүртэцгээе. Тэнгэрүүд дахин нээгдсэн байна. Есүс Христийн сайн мэдээ нь дэлхий дээр дахин оршиж байгаа бөгөөд үүний энгийн үнэнүүд нь баяр баясгалангийн элбэг дэлбэг эх булаг юм!

Ах эгч нараа, бидэнд үнэхээр баярлан наадах шалтгаан бий. Хэрэв амьдрал болон үүний яаруу хурдац мөн олон янзын дарамтууд ийнхүү баярлан наадахад тань саад болж байвал, магадгүй энэ нь хамгийн чухал зүйлс уруу чиглэх цаг юм.

Хүчин чадал гэдэг нь улайрсан үйл явдлуудаас биш харин үнэн болон гэрэл дээр бат бөх сууриа олсноор ирдэг юм. Энэ нь анхаарал болон зүтгэлээ Есүс Христийн сэр-гээгдсэн сайн мэдээний үндсэн зүйлс дээр төвлөрүүлсэнээр ирдэг. Энэ нь хамгийн чухал бурханлиг зүйлс дээр анхаарал хандуулснаар ирдэг.

Амьдралаа бага зэрэг энгийн болгоцгооё. Биднийг амар амгалан, баяр хөөртэй, утга бүхий амьдрал уруу хөтлөх зам болох Христийн дагалдагчийн даруу, энгийн замын

сайн сайхныг олж, амьдралаа дахин чиглүүлэхэд шаардлагатай өөрч-лөлтүүдийг хийцгээе. Үүний төлөө би залбирч, та бүхэнд адислалаа үлдээе. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Mahatma Gandhi, in Larry Chang, *Wisdom for the Soul* (2006), 356.
2. Даллин Х.Өүкс, "Good, Better, Best," *Лиахона*, 2007 оны 11-р сар, 107.
3. Leonardo da Vinci, in John Cook, comp., *The Book of Positive Quotations*, 2nd ed. (1993), 262.
4. Vince Lombardi, in Donald T. Phillips, *Run to Win: Vince Lombardi on Coaching and Leadership* (2001), 92.

5. Лук 18:22.
6. Хаадын дээд 19:12-г үз.
7. Мозая 4:27.
8. 2 Нифай 25:26.
9. 1Коринт12:31; Ифер12:11.
10. Иохан 14:6.
11. Дуулал 46:10.
12. J. E. McCulloch, *Home: The Savior of Civilization* (1924), 42; see also Conference Report, Apr. 1935, 116.

© 2010 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/09. Орчуулгын зөвшөөрөл: 6/09. *Visiting Teaching Message, November 2010.* Mongolian. 09371 363